



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ДААТГАЛЫН САЛБАРЫН
2023 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
НЭГДСЭН ТАЙЛАН

Улаанбаатар хот 2023



Хүснэгтийн жагсаалт	3
Хүснэгтийн жагсаалт	3
Дүрслэлийн жагсаалт.....	4
1. Даатгалын хөгжлийн үзүүлэлт.....	5
Даатгалын гүнзгийрэлт	5
2. Даатгалын салбарын ерөнхий мэдээлэл.....	6
2.1. Тусгай Зөвшөөрөл, Зөвшөөрөл, Бүртгэл, Эрхийн Мэдээлэл	6
2.2. Даатгагчийн Хөрөнгө.....	7
2.3. Даатгагчийн Өр Төлбөр Ба Эздийн Өмч.....	11
2.4. Даатгалын Хураамж	15
2.5. Даатгалын Нөхөн Төлбөр.....	17
2.7. Даатгалын Харьцаа.....	19
2.8. Даатгагчийн Ашигт Ажиллагаа	21
2.9. Давхар Даатгал	22
3. Ердийн даатгал	24
3.1. Ердийн даатгагчдын хөрөнгө	24
3.2. Ердийн даатгагчдын өр төлбөр ба эздийн өмч.....	25
3.3. Нөөц сан.....	26
3.4. Ердийн даатгалын хураамж	27
3.5. Ердийн даатгагчдын нөхөн төлбөр	30
4. Урт хугацааны даатгал.....	33
4.1. Урт хугацааны даатгагчийн хөрөнгө	33
4.2. Урт хугацааны даатгалын хураамж.....	33
4.3. Урт хугацааны даатгалын нөхөн төлбөр	34
5. Давхар даатгал.....	35
6. Албан журмын даатгал.....	36
7. Даатгалын мэргэжлийн оролцогч	38
7.1. Даатгалын зуучлагч	38
7.2. Даатгалын хохирол үнэлэгч	41
7.3. Даатгалын төлөөлөгч.....	43

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт №1. Даатгалын гүнзгийрэлтийн түвшин
- Хүснэгт №2. Бүртгэл, зөвшөөрлийн ерөнхий мэдээлэл
- Хүснэгт №3. Даатгагчдын хөрөнгө /ангилал тус бүрээр/
- Хүснэгт №4. Даатгагчдын хөрөнгө оруулалт /ангилал тус бүрээр/
- Хүснэгт №5. Даатгагчдын өр төлбөр ба эздийн өмч /ангилал тус бүрээр/
- Хүснэгт №6. Даатгалын нийт хураамжийн орлого
- Хүснэгт №7. Даатгалын нөхөн төлбөр
- Хүснэгт №8. Даатгалын харьцаа
- Хүснэгт №9. Даатгагчийн ашигт ажиллагаа /2019.III-2023.III/
- Хүснэгт №10. Давхар даатгалын хураамж
- Хүснэгт №11. Ердийн даатгагчдын хөрөнгө /ангилал тус бүрээр/
- Хүснэгт №12. Ердийн даатгагчдын өр төлбөр ба эздийн өмчийн дүн
- Хүснэгт №13. Ердийн даатгагчдын нөөц сан
- Хүснэгт №14. Ердийн даатгалын хураамж
- Хүснэгт №15. Ердийн даатгалын хураамж /даатгалын хэлбэрээр/
- Хүснэгт №16. Ердийн даатгалын нөхөн төлбөр
- Хүснэгт №17. Ердийн даатгалын нөхөн төлбөр /даатгалын хэлбэрээр/
- Хүснэгт №18. Урт хугацааны даатгагчдын хөрөнгө /ангилал тус бүрээр/
- Хүснэгт №19. Урт хугацааны даатгалын хураамж
- Хүснэгт №20. Урт хугацааны даатгалын нөхөн төлбөр
- Хүснэгт №21. Давхар даатгалын хураамж, нөхөн төлбөр
- Хүснэгт №22. ЖХАЖД-ын хураамж, нөхөн төлбөр /2019.III-2023.III/
- Хүснэгт №23. ЖХАЖД-ын хураамж, нөхөн төлбөр, хохирлын харьцаа
- Хүснэгт №24. Даатгалын зуучлалын дэлгэрэнгүй
- Хүснэгт №25. Зуучилсан даатгалын хураамж, зуучлалын шимтгэл
- Хүснэгт №26. Даатгалын хохирол үнэлгээ /даатгалын хэлбэрээр/
- Хүснэгт №27. Даатгалын хохирол үнэлгээ /компани тус бүрээр/
- Хүснэгт №28. Даатгалын төлөөлөгчөөр дамжин орсон даатгалын нийт хураамж

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

- Дүрслэл №1. Даатгалын гүнзгийрэлтийн түвшин
- Дүрслэл №2. Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө
- Дүрслэл №3. Даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувь /2019.III-2023.III/
- Дүрслэл №4. Хөрөнгө оруулалтын ангилал
- Дүрслэл №5. Даатгагчдын нийт өр төлбөр ба эздийн өмч
- Дүрслэл №6. Даатгагчдын өр төлбөр ба эздийн өмч /ангилал тус бүрээр/
- Дүрслэл № 7. Даатгалын компаниудын нөөц сангийн дүн өсөлтийн хувиар
- Дүрслэл №8. Даатгалын хураамжийн орлого /өсөлтийн хувиар/
- Дүрслэл №9. Даатгалын хураамжийн орлого /эзлэх хувиар/
- Дүрслэл №10. Даатгалын хураамж /борлуулалтын сувгаар/
- Дүрслэл №11. Даатгалын нөхөн төлбөр /өсөлтийн хувиар/
- Дүрслэл №12. Даатгалын компаниудын нөхөн төлбөр /эзлэх хувиар/
- Дүрслэл №13. Давхар даатгалын хураамж, нөхөн төлбөрийн харьцаа
- Дүрслэл №14. Ердийн даатгагчдын хөрөнгийн ангилал /эзлэх хувиар/
- Дүрслэл №15. Ердийн даатгалын хураамжийн орлогод эзлэх хувь /даатгалын хэлбэр/
- Дүрслэл №16. Ердийн даатгалын нөхөн төлбөрийн эзлэх хувь /даатгалын хэлбэрээр/
- Дүрслэл №17. Зуучилсан даатгалын хураамжийн орлогын эзлэх хувь /даатгалын хэлбэрээр/
- Дүрслэл №18. Зуучилсан даатгалын хураамж, зуучлалын шимтгэл /сая.төг/
- Дүрслэл №19. Даатгалын нийт хохирол үнэлгээ /эзлэх хувь/
- Дүрслэл №20. Даатгалын төлөөлөгчийн даатгалын нийт хураамж бүрдүүлэлтийн эзлэх хувь /даатгалын хэлбэрээр/

1. ДААТГАЛЫН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ДААТГАЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ


2023 оны 3 дугаар улирлын байдлаар Монгол Улсын даатгалын гүнзгийрэлтийн түвшин өмнөх оны мөн үеэс 0.02 функтээр буурч 0.6 хувь байна. Учир нь даатгалын хураамжийн нийт орлого өмнөх оны мөн үеэс 31.9 хувиар өссөн байхад Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 36.3 хувиар өссөн нь даатгалын гүнзгийрэлтийн түвшин буурахад нөлөөлсөн байна. /Хүснэгт №1 болон Дүрслэл №1-д тус тус дэлгэрэнгүй харуулав/

Хүснэгт №1. Даатгалын гүнзгийрэлтийн түвшин

Он	Даатгалын нийт хураамжийн орлого /сая.төг/				ДНБ ¹	Монгол улсын гүнзгийрэлт
	Ердийн даатгал	Урт хугацааны даатгал	Давхар даатгал	Нийт		
2016.III	87,858.4	928.9	0.0	88,787.2	17,258,889.9	0.51%
2017.III	112,035.0	995.6	1,541.4	114,572.1	19,895,846.2	0.58%
2018.III	123,656.4	1,020.8	1,717.9	126,395.1	23,460,012.8	0.54%
2019.III	155,821.7	923.7	1,993.7	158,739.1	26,144,062.9	0.61%
2020.III	158,922.7	1,019.7	3,466.1	163,408.5	26,148,237.5	0.62%
2021.III	187,180.9	1,311.6	3,542.6	192,035.1	36,958,600.0	0.52%
2022.III	214,215.8	2,113.3	3,518.9	219,848.0	35,234,047.8	0.62%
2023.III	280,639.6	2,872.4	6,519.9	290,031.8	48,009,068.3	0.60%

* Даатгалын гүнзгийрэлт гэж даатгалын нийт хураамжийн орлогыг Дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаа

Дүрслэл №1. Даатгалын гүнзгийрэлтийн түвшин



¹ <https://www.1212.mn/mn>

2. ДААТГАЛЫН САЛБАРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2.1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛ, ЭРХИЙН МЭДЭЭЛЭЛ

Даатгалын бүтээгдэхүүний тоо 6.7 хувиар өсөж, 705 даатгалын бүтээгдэхүүн зах зээлд борлуулагдаж байна



18.1%

Салбарын хувьцаа эзэмшигчдийн тоо 23.8%-аар өсөв

2023 оны 3 дугаар улирлын байдлаар Хорооноос тусгай зөвшөөрөлтэйгээр 18 даатгалын компани, үүнээс 15 ердийн даатгалын компани, 2 урт хугацааны даатгалын компани, 1 давхар даатгалын компани, мөн 64 даатгалын зуучлагч компани, үүнээс 10 даатгалын зуучлагч банк болон 25 даатгалын хохирол үнэлэгч, 2381 даатгалын төлөөлөгч тус тус үйл ажиллагаа эрхлэн явуулж байна. Мөн 44 аудитын компанийн 145 аудитор, 40 актуарч тус тус Хорооноос олгосон эрхийн дагуу даатгалын салбарт үйл ажиллагаа эрхэлж байна. /Хүснэгт №2-т дэлгэрэнгүй харуулав/

Хүснэгт №2. Бүртгэл, зөвшөөрлийн ерөнхий мэдээлэл

№	Ерөнхий мэдээлэл	2022.III	2023.III	Ө/Б
1	Даатгалын компанийн тоо	17	18	5.9%
	Ердийн даатгал	15	15	0.0%
	Үүнээс гадаадын хөрөнгө оруулалттай	2	2	0.0%
	Урт хугацааны даатгалын компани	1	2	100.0%
	Давхар даатгалын компани	1	1	0.0%
2	Даатгалын зуучлагч компани	62	64	3.2%
	Үүнээс: банк-зуучлагч	10	10	0.0%
	давхар даатгалын зуучлагч	12	11	-8.3%
3	Даатгалын хохирол үнэлэгч компани	25	25	0.0%
4	Даатгалын төлөөлөгч	2298	2381	3.6%
	Үүнээс: Компани	6	6	0.0%
	Хотод ажиллах төлөөлөгч	535	601	12.3%
5	Салбарын тоо	683	690	1.0%
	Үүнээс Даатгалын компанийн	246	238	-3.3%
	Үүнээс УБ-т	43	39	-9.3%
	Даатгалын зуучлагчийн	391	404	3.3%

	Ердийн болон давхар даатгалын зуучлагчийн салбар	99	111	12.1%
	үүнээс УБ-г	24	29	20.8%
	банк-зуучлагчийн салбар	292	293	0.3%
	үүнээс УБ-г	184	185	0.5%
	Даатгалын хохирол үнэлэгчийн	46	48	4.3%
	үүнээс УБ-г	31	33	6.5%
6	Төлөөлөгчийн газрын тоо	54	55	1.9%
	Үүнээс Даатгалын компанийн	12	13	8.3%
	үүнээс УБ-г	5	4	-20.0%
	Даатгалын зуучлагчийн	0	0	0.0%
	Үүнээс: банк-зуучлагчийн	0	0	0.0%
	Даатгалын хохирол үнэлэгчийн	42	42	0.0%
	үүнээс УБ-г	10	10	0.0%
7	Даатгалын бүтээгдэхүүний тоо	661	705	6.7%
8	Эрх бүхий албан тушаалтны тоо	320	334	4.4%
	Үүнээс: даатгалын компанийн	166	174	4.8%
	даатгалын зуучлагчийн	105	111	5.7%
	даатгалын хохирол үнэлэгчийн	49	49	0.0%
9	Аудитын компанийн тоо	40	44	10.0%
	Аудиторын тоо	137	145	5.8%
10	Даатгалын байгууллагын хувьцаа эзэмшигчдийн тоо	18282	22632	23.8%
	Үүнээс: Даатгалын зуучлагчийн	116	114	-1.7%
	Даатгалын хохирол үнэлэгчийн	51	48	-5.9%
	Даатгалын компанийн	18115	22470	24.0%
	Үүнээс: ХХК-ийн хувьд	38	42	10.5%
	нээлттэй ХК-ийн хувьд	18077	22428	24.1%
	Хуулийн этгээд	17	23	35.3%
11	Актуарчийн тоо /Хорооноос эрх олгосон/	40	40	0.0%

Даатгалын байгууллагын хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 23.8 хувиар өссөн байна. Энэ нь даатгалын салбарт хөрөнгө оруулагчдын тоо өсөж, тус зах зээлээс өгөөж хүртэгсэд нэмэгдэн салбарын хамрах хүрээ өргөжиж байгааг илтгэж байна.

2.2. ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ



Нийт хөрөнгө 582.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.6%-аар өссөн байна.

Даатгалын компаниудын нийт хөрөнгө 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 582.5 тэрбум төгрөгт хүрсэн ба өмнөх оны мөн үеэс 29.6 хувиар өссөн байна. 2019-2023

8 | Даатгалын салбарын 2023 оны 3 дугаар улирлын үйл ажиллагааны нэгдсэн тайлан

онуудын 3 дугаар улирлын тоон мэдээллүүдийг харьцуулан харахад энэ онд хамгийн өндөр буюу 29.6 хувиар өсчээ. /Хүснэгт №3, Дүрслэл №2-т тус тус дэлгэрэнгүй харуулав/

Мөн хөрөнгийн ангиллаар авч үзвэл хөрөнгө оруулалтын дүн нийт хөрөнгийн дүнд хамгийн өндөр буюу 53.5 хувийг эзэлж байна.

2019.III-2023.III он хүртэлх даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгийн талаар мэдээллийг дараах холбоосоор дэлгэрэнгүй харна уу. [/Хорооны цахим хуудас дахь excel file руу шилжих/](#)


Хүснэгт №3. Даатгагчдын хөрөнгө /ангилал тус бүрээр/

ОН	Хөрөнгийн ангилал	Нийт дүнгээр /сая.төг/				Эзлэх хувь /%/		
		НИЙТ	Ердийн	Урт	Давхар	Ердийн	Урт	Давхар
2019.III	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	44,900.0	20,869.6	171.1	23,859.3	46.5%	0.4%	53.1%
	Даатгалын авлагын дүн	26,758.2	26,720.8	0.1	37.4	99.9%	0.0%	0.1%
	Хөрөнгө оруулалтын дүн	154,889.8	148,415.1	6,351.0	123.7	95.8%	4.1%	0.1%
	Үндсэн хөрөнгө /Цэвэр/	76,700.4	24,821.1	2,455.0	49,424.3	32.4%	3.2%	64.4%
	Биет бус хөрөнгө /Цэвэр/	1,258.2	659.2	42.2	556.8	52.4%	3.4%	44.3%
	Бусад	58,710.9	58,246.8	120.5	343.7	99.2%	0.2%	0.6%
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	363,836.6	279,732.7	9,139.8	74,964.1	76.9%	2.5%	20.6%
2020.III	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	22,512.1	18,425.6	90.8	3,995.6	81.8%	0.4%	17.7%
	Даатгалын авлагын дүн	36,524.9	32,895.8	0.8	3,628.3	90.1%	0.0%	9.9%
	Хөрөнгө оруулалтын дүн	222,484.3	167,621.3	7,013.0	47,850.0	75.3%	3.2%	21.5%
	Үндсэн хөрөнгө /Цэвэр/	28,974.4	26,110.1	2,370.5	493.8	90.1%	8.2%	1.7%
	Биет бус хөрөнгө /Цэвэр/	1,411.6	841.8	36.0	533.8	59.6%	2.5%	37.8%
	Бусад	77,336.4	76,206.9	129.9	999.6	98.5%	0.2%	1.3%
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	390,693.1	323,550.9	9,641.0	57,501.2	82.8%	2.5%	14.7%
2021.III	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	40,794.8	35,836.9	89.3	4,868.6	87.8%	0.2%	11.9%
	Даатгалын авлагын дүн	39,761.3	35,576.1	0.5	4,184.6	89.5%	0.0%	10.5%
	Хөрөнгө оруулалтын дүн	234,146.2	175,285.9	6,785.3	52,075.0	74.9%	2.9%	22.2%
	Үндсэн хөрөнгө /Цэвэр/	31,450.1	28,707.7	2,287.3	455.1	91.3%	7.3%	1.4%

9 | Даатгалын салбарын 2023 оны 3 дугаар улирлын үйл ажиллагааны нэгдсэн тайлан


	Биет бус хөрөнгө /Цэвэр/	933.2	468.4	20.4	444.5	50.2%	2.2%	47.6%
	бусад	79,698.8	78,661.1	364.8	673.0	98.7%	0.5%	0.8%
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	444,936.4	372,688.0	9,547.7	62,700.8	83.8%	2.1%	14.1%
2022.III	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	28,551.4	24,445.3	838.6	3,267.5	85.6%	2.9%	11.4%
	Даатгалын авлагын дүн	35,628.2	34,937.7	23.2	667.3	98.1%	0.1%	1.9%
	Хөрөнгө оруулалтын дүн	260,192.1	198,718.6	6,793.9	54,679.7	76.4%	2.6%	21.0%
	Үндсэн хөрөнгө /Цэвэр/	32,297.8	29,599.2	2,165.5	533.1	91.6%	6.7%	1.7%
	Биет бус хөрөнгө /Цэвэр/	827.4	479.2	6.5	341.6	57.9%	0.8%	41.3%
	Бусад	92,121.1	91,104.1	320.8	696.2	98.9%	0.3%	0.8%
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	449,618.1	379,284.1	10,148.6	60,185.5	84.4%	2.3%	13.4%
2023.III	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	73,583.8	70,351.3	524.2	2,708.3	95.6%	0.7%	3.7%
	Даатгалын авлагын дүн	39,271.5	35,599.8	51.4	3,620.4	90.7%	0.1%	9.2%
	Хөрөнгө оруулалтын дүн	311,405.8	239,058.9	13,527.2	58,819.6	76.8%	4.3%	18.9%
	Үндсэн хөрөнгө /Цэвэр/	36,219.2	35,822.2	120.8	276.3	98.9%	0.3%	0.8%
	Биет бус хөрөнгө /Цэвэр/	5,254.1	4,935.3	46.7	272.0	93.9%	0.9%	5.2%
	Бусад	116,755.5	109,872.2	1,988.5	4,894.9	94.1%	1.7%	4.2%
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	582,490.0	495,639.6	16,258.8	70,591.5	85.1%	2.8%	12.1%

Дүрслэл №2. Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө



Даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувийг даатгагчийн төрлөөр авч үзвэл ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө 495.6 тэрбум төгрөг буюу нийт даатгагчдын хөрөнгийн 85.1 хувийг, урт хугацааны даатгалын компаниудын нийт хөрөнгө 16.3 тэрбум төгрөг буюу нийт даатгагчдын хөрөнгийн 2.8 хувийг, давхар даатгалын компанийн хөрөнгө 70.6 тэрбум төгрөг буюу нийт даатгагчдын хөрөнгийн 12.1 хувийг тус тус эзэлж байна. /Дүрслэл №3-т дэлгэрэнгүй харуулав/

Дүрслэл №3. Даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувь /2019.III-2023.III/




Даатгагчдын хөрөнгө оруулалтыг өсөлтийн хувиар авч үзвэл хадгаламж, хадгаламжийн сертификатад оруулах хөрөнгө оруулалт 20.2 хувиар, мөн нийт хөрөнгө оруулалт 19.7 хувиар тус тус өссөн байна. Мөн үнэт цаас хэлбэрээр оруулж буй хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.6 хувиар өссөн нь хөрөнгийн зах зээл дахь даатгалын компаниудын оролцоо нэмэгдэж буйг харуулж байна. /Хүснэгт №4, Дүрслэл №4-т дэлгэрэнгүй харуулав/

Хүснэгт №4. Даатгагчдын хөрөнгө оруулалт /ангилал тус бүрээр/

ОН	Хөрөнгийн ангилал	Нийт дүнгээр /сая.төг/			
		НИЙТ	Ердийн	Урт	Давхар
2019.III	Хадгаламж, хадгаламжийн сертификат	185,961.3	131,031.2	5,549.6	49,380.6
	Үнэт цаас /цэвэр/	22,146.9	21,345.5	801.4	-
	НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДҮН	208,108.3	152,376.7	6,351.0	49,380.6
2020.III	Хадгаламж, хадгаламжийн сертификат	190,281.0	136,848.0	5,583.0	47,850.0
	Үнэт цаас /цэвэр/	32,203.3	30,773.3	1,430.0	-
	НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДҮН	222,484.3	167,621.3	7,013.0	47,850.0
2021.III	Хадгаламж, хадгаламжийн сертификат	181,467.0	125,422.6	3,969.4	52,075.0
	Үнэт цаас /цэвэр/	48,878.7	46,062.8	2,815.9	-
	НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДҮН	234,146.2	175,285.9	6,785.3	52,075.0

2022.III	Хадгаламж, хадгаламжийн сертификат	181,177.0	126,105.4	5,391.6	49,680.0
	Үнэт цаас /цэвэр/	78,615.1	72,213.2	1,402.2	4,999.7
	НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДҮН	260,192.2	198,718.6	6,793.9	54,679.7
2023.III	Хадгаламж, хадгаламжийн сертификат	217,804.5	151,698.2	7,840.6	58,265.8
	Үнэт цаас /цэвэр/	93,201.3	86,960.8	5,686.6	553.9
	НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДҮН	311,405.8	239,058.9	13,527.2	58,819.6

Дүрслэл №4. Хөрөнгө оруулалтын ангилал



2019.III-2023.III он хүртэлх даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгийн талаар мэдээллийг дараах холбоосоор дэлгэрэнгүй харна уу. [/Хорооны цахим хуудас дахь excel file руу шилжих/](#)

2.3. ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ



Тайлант хугацаанд нөөц сангийн нийт дүн 268.6 тэрбум төгрөгт хүрлээ.

2023 оны 3 дугаар улирлын байдлаар нийт өр төлбөрт ердийн даатгагчид 87.9 хувь, урт хугацааны даатгагчид 0.9 хувь, давхар даатгагч 11.2 хувийг тус тус эзэлж байна. Мөн эздийн өмчийн дүнгийн дийлэнх хувийг ердийн даатгагчид эзэлж байна. /Хүснэгт №5 болон Дүрслэл №5-д тус тус дэлгэрэнгүй харуулав/


2019.III-2023.III он хүртэлх даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эздийн өмчийн талаар мэдээллийг дараах холбоосоор дэлгэрэнгүй харна уу. [/Хорооны цахим хуудас дахь excel file руу шилжих/](#)

Хүснэгт №5. Даатгагчдын өр төлбөр ба эздийн өмч /ангилал тус бүрээр/

Өр төлбөр, нөөц сан		Нийт /сая.төг/	Ердийн /сая.төг/	Эзлэх хувь	Урт /сая.төг/	Эзлэх хувь	Давхар /сая.төг/	Эзлэх хувь
2019.III	Даатгалын өглөгийн дүн	19,318.3	18,384.5	95.2%	0.0	0.0%	933.7	4.8%
	Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн	1,960.4	1,870.0	95.4%	0.0	0.0%	90.4	4.6%
	Нөөц сангийн дүн	165,747.2	136,504.3	82.4%	2,249.3	1.4%	26,993.7	16.3%
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	190,701.2	160,081.7	83.9%	2,257.2	1.2%	28,362.3	14.9%
	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	173,135.4	119,650.9	69.1%	6,882.6	4.0%	46,601.8	26.9%
2020.III	Даатгалын өглөгийн дүн	21,155.4	20,279.4	95.9%	18.0	0.1%	857.9	4.1%
	Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн	4,544.3	4,455.0	98.0%	0.0	0.0%	89.2	2.0%
	Нөөц сангийн дүн	180,489.7	150,731.8	83.5%	2,621.4	1.5%	27,136.5	15.0%
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	212,832.4	180,229.6	84.7%	2,669.1	1.3%	29,933.7	14.1%
	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	177,860.6	143,321.3	80.6%	6,971.8	3.9%	27,567.5	15.5%
2021.III	Даатгалын өглөгийн дүн	23,730.8	22,684.7	95.6%	18.4	0.1%	1,027.7	4.3%
	Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн	7,897.5	5,055.2	64.0%	0.0	0.0%	2,842.3	36.0%
	Нөөц сангийн дүн	203,095.3	174,951.8	86.1%	2,606.6	1.3%	25,536.8	12.6%
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	246,935.5	211,750.6	86.1%	2,682.4	1.3%	32,502.5	12.6%
	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	198,001.0	160,937.3	81.3%	6,865.3	3.5%	30,198.4	15.2%
2022.III	Даатгалын өглөгийн дүн	18,111.0	17,319.3	95.6%	8.1	0.1%	783.6	4.3%
	Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн	13,312.2	12,372.0	92.9%	0.0	0.0%	940.2	7.1%
	Нөөц сангийн дүн	207,907.1	174,810.9	84.1%	3,113.5	1.5%	29,982.7	14.4%
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	248,543.8	212,528.6	85.5%	3,192.3	1.3%	32,822.9	13.2%


	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	201,074.3	166,755.4	82.9%	6,956.3	3.5%	27,362.6	13.6%
2023.III	Даатгалын өглөгийн дүн	57,530.4	56,265.9	97.7%	13.0	0.1%	1,251.6	2.2%
	Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн	18,320.1	18,116.6	98.9%	9.1	0.1%	184.4	1.0%
	Нөөц сангийн дүн	268,581.1	230,905.9	86.0%	2,995.0	1.1%	34,680.1	12.9%
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	356,972.4	313,731.4	87.9%	3,135.8	0.9%	40,105.1	11.2%
	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	225,517.6	181,908.2	80.7%	13,123.0	5.8%	30,486.4	13.5%

Дүрслэл №5. Даатгагчдын нийт өр төлбөр ба эздийн өмч




Сүүлийн 5 жилийн байдлаар даатгагчдын нөөц сан нь эздийн өмчийн дүнтэй ойролцоо байгаа ба нийт өр төлбөрийн дийлэнх хувийг буюу 75.2 хувийг даатгалын нөөц сан эзэлж байна. Тайлант үед даатгагчдын нөөц сан 268.6 тэрбум төгрөг, эздийн өмч 225.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. /Дүрслэл №6-д дэлгэрэнгүй харуулав/

Дүрслэл №6. Даатгагчдын өр төлбөр ба эздийн өмч /ангилал тус бүрээр/



Тайлант хугацаанд урт хугацааны даатгалын компаниудын нөөц сан 3.8 хувиар буурч 3.2 тэрбум төгрөгөөс 3.0 тэрбум төгрөгт хүрсэн бол, ердийн даатгалын компаниудын нөөц сан 32.1 хувиар өсч 230.9 тэрбум төгрөгт хүрсэн байна./Дүрслэл №7-д дэлгэрэнгүй харуулав/

Дүрслэл № 7. Даатгалын компаниудын нөөц сангийн дүн өсөлтийн хувиар



2019.III-2023.III он хүртэлх даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эздийн өмчийн талаар мэдээллийг дараах холбоосоор дэлгэрэнгүй харна уу. [Линк](#) /Хорооны цахим хуудас дахь excel file руу шилжих/

2.4. ДААТГАЛЫН ХУРААМЖ



Даатгалын нийт хураамжийн орлого өмнөх оны мөн үеэс **31.9 хувиар өссөн** бол нийт даатгалын хураамжийн **1.0 хувийг** урт хугацааны даатгалын хураамжийн орлого эзэлж байна.

2023 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын болон давхар даатгалын нийт хураамжийн орлого 290.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнээс ердийн даатгалын нийт хураамжийн орлого 280.6 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын нийт хураамжийн орлого 2.9 тэрбум төгрөг, давхар даатгалын хураамжийн орлого 6.5 тэрбум төгрөгт хүрчээ. Мөн ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нь 146.3 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий даатгалын эрсдэлийг хүлээн авсан байна. /Хүснэгт №6-д дэлгэрэнгүй харуулав/

2019.III-2023.III он хүртэлх даатгалын болон давхар даатгалын компаниудын орлогын дэлгэрэнгүй тайлан, мэдээллийг дараах холбоосоор дэлгэрэнгүй харна уу. [/Хорооны цахим хуудас дахь excel file руу шилжих/](#)


Хүснэгт №6. Даатгалын нийт хураамжийн орлого

Даатгалын нийт хураамжийн орлого /сая.төг/						
Даатгалын компаниуд		2019.III	2020.III	2021.III	2022.III	2023.III
Ердийн даатгал	Монре даатгал	5,410.0	4,398.5	4,671.5	7,121.0	4,563.6
	Ард даатгал	8,171.7	10,965.4	11,092.6	15,694.8	22,792.5
	Бодь даатгал	26,096.9	29,520.6	47,178.8	21,499.5	20,173.7
	Мөнх даатгал	1,774.7	4,257.9	5,114.0	8,800.2	13,941.9
	Миг даатгал	20,146.8	14,980.4	17,815.4	25,296.0	35,528.5
	Монгол даатгал	26,772.4	17,720.3	22,934.3	15,844.9	22,765.9
	Тэнгэр даатгал	13,847.7	12,326.3	9,886.4	8,512.1	12,314.6
	Номин даатгал	6,443.8	6,924.1	7,038.5	9,348.8	13,380.9
	Улаанбаатар хотын даатгал	847.0	905.3	928.1	1,207.3	1,330.0
	Амар даатгал	4,578.7	6,491.8	5,236.5	6,508.5	14,760.9
	Ган зам даатгал	618.5	682.6	571.7	738.0	1,153.5
	Практикал даатгал	9,380.3	15,875.3	14,592.9	19,083.0	22,945.8
	Мандал даатгал	22,887.0	27,904.1	29,984.6	59,218.5	75,555.2
	Хаан даатгал	7,141.6	5,970.1	10,122.1	11,725.5	16,194.3
	Агула даатгал			13.6	3,617.8	3,238.2
	Соёмбо даатгал	1,704.6				
	Нийт	155,821.7	158,922.7	187,180.9	214,215.8	280,639.6
Нэйшнл лайф даатгал	923.7	1,019.7	1,311.6	2,113.30	2,857.7	

Урт хугацааны даатгал	Мандал лайф даатгал					14.6
	Нийт	923.7	1,019.7	1,311.6	2,113.3	2,872.4
Урт ба ердийн нийт		156,745.4	159,942.4	188,492.5	216,329.1	283,511.9
Давхар даатгал	Үндэснийд давхар даатгал	1,963.3	3,466.1	3,542.6	3,518.9	6,519.8
	Хубилай давхар даатгал	30.4				
	Нийт	1,993.7	3,466.1	3,542.6	3,518.9	6,519.8
Нийт даатгалын компаниудын		158,739.1	163,408.5	192,035.1	219,848.0	290,031.8


Урт хугацааны даатгалын компанийн хураамжийн орлого өмнөх оны мөн үеэс 35.9 хувиар, ердийн даатгалын компаниудын хураамжийн орлого өмнөх оны мөн үеэс 31.0 хувиар, давхар даатгалын компанийн хураамжийн орлого өмнөх оны мөн үеэс 85.3 хувиар тус тус өссөн байна. /Дүрслэл №8-д дэлгэрэнгүй харуулав/

Дүрслэл №8. Даатгалын хураамжийн орлого /өсөлтийн хувиар/




Сүүлийн 5 жилийн байдлаар урт хугацааны даатгалын хураамжийн орлого нийт даатгалын салбарын хураамжийн орлогын 1.0 хүрэхгүй хувийг бүрдүүлж байгаа хэдий ч урт хугацааны даатгалын хураамжийн орлогын өсөлт 28.6-61.1 хувь хүртэл байгаа нь урт хугацааны даатгалын хураамжийн орлого тогтмол өсөх хандлагатай байгааг илтгэж байна. /Дүрслэл №9-д дэлгэрэнгүй харуулав./

Дүрслэл №9. Даатгалын хураамжийн орлого /эзлэх хувиар/



Даатгалын хураамжийн орлого бүрдүүлэлтийг борлуулалтын сувгаар нь авч үзвэл даатгалын нийт хураамжийн орлогын 31.1 хувь нь даатгалын төлөөлөгчөөр, 14.8 хувь нь даатгалын зуучлагч компаниар, банк даатгалын зуучлагч компаниар 11.2 хувь нь дамжин бүрдсэн байна. /Дүрслэл №10-т дэлгэрэнгүй харуулав/

Дүрслэл №10. Даатгалын хураамж /борлуулалтын сувгаар/



2.5. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР



Даатгалын нийт нөхөн төлбөр 82.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 19.2%-аар өссөн байна.

2023 оны 3 дугаар улирлын байдлаар нийт даатгалын нөхөн төлбөр 82.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 19.2 хувиар өссөн байна. Үүнээс хамгийн их буюу 11.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг “Миг даатгал” ХХК, 11.1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг “Бодь даатгал” ХК тус тус олгосон байна. /Хүснэгт №7-д дэлгэрэнгүй харуулав/

2019.III-2023.III он хүртэлх даатгалын болон давхар даатгалын компаниудын орлогын дэлгэрэнгүй тайлан, мэдээллийг дараах холбоосоор дэлгэрэнгүй харна уу.
[/Хорооны цахим хуудас дахь excel file руу шилжих/](#)


Хүснэгт №7. Даатгалын нөхөн төлбөр

Даатгалын нөхөн төлбөр /сая.төг/						
Даатгалын компаниуд		2019.III	2020.III	2021.III	2022.III	2023.III
Ердийн даатгал	Монре даатгал	1,895.7	2,382.5	1,630.4	3,305.6	4,762.4
	Ард даатгал	3,076.2	3,638.3	3,168.0	5,810.1	8,289.0
	Бодь даатгал	6,005.4	6,544.2	6,195.6	10,119.3	11,145.9
	Мөнх даатгал	181.1	880.0	1,382.1	2,666.5	4,643.0
	Миг даатгал	5,249.8	5,152.8	4,701.2	8,590.3	11,617.1
	Монгол даатгал	6,946.9	6,439.0	5,933.7	5,755.6	5,150.9
	Тэнгэр даатгал	3,319.0	3,406.0	1,735.3	2,433.6	3,472.7
	Номин даатгал	1,872.8	2,843.6	5,487.8	7,634.5	5,100.6
	Улаанбаатар хотын даатгал	174.5	175.1	79.2	131.3	140.8
	Амар даатгал	207.9	851.0	1,209.4	1,496.7	2,772.3
	Ган зам даатгал	63.1	105.7	178.0	299.4	63.1
	Практикал даатгал	3,676.6	3,374.0	3,598.7	8,080.3	8,106.2
	Мандал даатгал	3,321.9	5,281.7	5,537.7	8,145.4	9,597.8
	Хаан даатгал	2,787.5	1,989.9	2,534.7	3,377.3	4,693.0
	Агула даатгал				144.7	947.8
	Соёмбо даатгал	981.1				
	Нийт	39,759.5	43,063.7	43,371.9	67,990.6	80,502.5
Урт хугацааны даатгал	Нэйшнл лайф даатгал	453.0	439.5	1,555.0	902.9	1,619.4
	Мандал лайф даатгал					-
	Нийт	453.0	439.5	1555.0	902.9	1619.4
Урт ба ердийн нийт		40,212.5	43,503.2	44,926.9	68,893.5	82,121.9
Давхар даатгал	Үндэсний давхар даатгал	18.5	0	860.4	126.1	2,645.3
	Хубилай давхар даатгал	-				
	Нийт	18.5	-	860.4	126.1	2,645.3
Нийт нөхөн төлбөр		40,231.0	43,503.2	45,787.4	69,019.6	84,767.2


Даатгалын компаниудын 2019-2023 онуудын 3 дугаар улирлын байдлаарх даатгалын нөхөн төлбөрийн дүнг авч үзвэл 2019-2021 онуудын 3 дугаар улиралд 40 гаруй тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийн зардал гарч байсан бол 2022 болон 2023

онуудын нөхөн төлбөрийн зардал харьцангуй өндөр буюу ойролцоогоор 2 дахин нэмэгдсэн байна. 2023 оны 3 дугаар улиралд олгосон нийт нөхөн төлбөрийн 95.0 хувийг ердийн даатгалын нөхөн төлбөр эзэлж байна /Дүрслэл №11, №12-т тус тус дэлгэрэнгүй харуулав/

Дүрслэл №11. Даатгалын нөхөн төлбөр /өсөлтийн хувиар/



Дүрслэл №12. Даатгалын компаниудын нөхөн төлбөр /эзлэх хувиар/



2.7. ДААТГАЛЫН ХАРЬЦАА



Ердийн даатгалын хохирлын харьцаа: **51.9%**

Урт хугацааны даатгалын хохирлын харьцаа: **62.3%**



Тайлант хугацаанд хохирлын харьцаа (давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөрийг оруулж тооцсон болно) ердийн даатгалын компаниудын хувьд 51.9 хувь, урт хугацааны даатгалын компанийн хувьд 62.3 хувь байгаа бол хосолсон харьцаа 109.8 хувь болон 128.9 хувьтай байна. Энэ нь тайлант хугацаанд даатгалын компаниуд даатгалын үйл ажиллагаанаас алдагдалтай ажилсныг илтгэж байна. /Хүснэгт №8-д дэлгэрэнгүй харуулав/

Хүснэгт №8. Даатгалын харьцаа

№	Ердийн даатгал					
	Даатгалын компани	Орлогод тооцсон хураамж	Нийт нөхөн төлбөрийн зардал	Үйл ажиллагааны зардал	Хохирлын харьцаа	Хосолсон харьцаа
1	Монре даатгал	4,390.1	4,762.4	2,778.8	108.5%	171.8%
2	Ард даатгал	14,926.1	8,289.0	7,808.8	55.5%	107.8%
3	Бодь даатгал	17,292.6	11,145.9	8,650.2	64.5%	114.5%
4	Мөнх даатгал	9,714.2	4,643.0	5,800.1	47.8%	107.5%
5	Миг даатгал	23,866.1	11,617.1	13,998.5	48.7%	107.3%
6	Монгол даатгал	12,500.9	5,150.9	9,206.1	41.2%	114.8%
7	Тэнгэр даатгал	7,032.1	3,472.7	4,368.3	49.4%	111.5%
8	Номин даатгал	11,690.0	5,100.6	6,128.6	43.6%	96.1%
9	Улаанбаатар хотын даатгал	1,301.1	140.8	1,155.7	10.8%	99.6%
10	Амар даатгал	5,634.6	2,772.3	2,948.1	49.2%	101.5%
11	Ган зам даатгал	677.8	63.1	369.7	9.3%	63.9%
12	Практикал даатгал	16,564.1	8,106.2	9,053.0	48.9%	103.6%
13	Мандал даатгал	17,234.3	9,597.8	10,095.9	55.7%	114.3%
14	Хаан даатгал	10,275.6	4,693.0	5,599.8	45.7%	100.2%
15	Агула даатгал	2,089.9	947.8	2,006.0	45.4%	141.3%
НИЙТ		155,189.4	80,502.5	89,967.4	51.9%	109.8%
Урт хугацааны даатгал						
	Даатгалын компани	Даатгалын цэвэр хураамжийн орлого	Нийт төлсөн нэхэмжлэл	Үйл ажиллагааны зардлын дүн	Хохирлын харьцаа	Хосолсон харьцаа
1	Нэйшнл лайф даатгал	2,585.4	1,619.4	1,196.6	62.6%	108.9%
2	Мандал лайф даатгал	14.4	0	534.9	0.0%	3706.2%
НИЙТ		2,599.8	1,619.4	1,731.5	62.3%	128.9%
Давхар даатгалын компани						
1	Үндэсний давхар даатгал	2,595.0	2,645.3	2,529.0	101.9%	199.4%

2.8. ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА



Салбарын цэвэр ашиг **7.4** тэрбум төгрөг болж, өмнөх оноос **19.8%-иар** буурсан байна.

2023 оны 3 дугаар улирлын байдлаар ердийн даатгалын компаниудын хувьд 4.6 тэрбум төгрөгийн, давхар даатгалын компани 2.3 тэрбум төгрөгийн, урт хугацааны даатгалын компаниуд 364.6 сая төгрөгийн ашигтай тус тус ажиллажээ. Дээрх хүснэгт №7-д харуулсанаар даатгалын компаниудын хосолсон харьцаа 100 хувиас давж даатгалын компаниудын даатгалын үйл ажиллагаанаас алдагдалтай байсан бол тайлант үеийн цэвэр ашиг эерэг үзүүлэлттэй гарсан нь даатгалын компаниуд хөрөнгө оруулалтын өгөөжөөрөө дийлэнх ашигаа бүрдүүлж байна. Гэвч даатгагчийн ашигт ажиллагаа өмнөх оны мөн үеэс 19.8 хувиар буурсан үзүүлттэй байна. /Хүснэгт №9-д дэлгэрэнгүй харуулав/

Хүснэгт №9. Даатгагчийн ашигт ажиллагаа /сая.төгрөгөөр/

№	Даатгалын компани	2019.III	2020.III	2021.III	2022.III	2023.III	Ө/Б 2022.III-2023.III
Ердийн даатгалын компани							
1	Монре даатгал	981.1	428.3	936.4	144.1	(3,542.4)	-2558.99%
2	Ард даатгал	1,730.6	889.5	7,860.1	1,748.0	1,260.3	-27.90%
3	Бодь даатгал	1,026.7	665.4	565.8	335.0	14.5	-95.66%
4	Мөнх даатгал	180.2	549.0	181.9	451.4	877.5	94.39%
5	Миг даатгал	182.4	197.1	500.0	1,146.6	1,095.8	-4.43%
6	Монгол даатгал	108.6	151.2	281.0	63.2	(1,175.6)	-1960.68%
7	Тэнгэр даатгал	813.5	1,415.8	1,815.2	1,927.4	3,223.6	67.25%
8	Номин даатгал	798.7	598.3	416.7	767.6	776.6	1.18%
9	Улаанбаатар хотын даатгал	59.6	562.4	302.7	114.3	192.1	68.14%
10	Амар даатгал	-221.2	1,143.6	966.9	1,134.8	755.0	-33.46%
11	Ган зам даатгал	764.2	724.2	465.8	628.5	779.5	24.01%
12	Практикал даатгал	1,248.2	2,696.4	454.4	(1,356.4)	(1,954.9)	44.13%
13	Мандал даатгал	4,562.4	3,541.4	4,333.2	2,781.8	3,002.1	7.92%
14	Хаан даатгал	13.1	1,011.6	267.2	1,765.7	561.7	-68.19%
15	Агула даатгал			55.2	197.0	(1,239.8)	-729.44%
16	Соёмбо	-14.9					
Нийт		12,646.0	14,574.1	19,402.5	11,849.0	4,626.1	-61.0%
Урт хугацааны даатгалын компани							
1	Нэйшнл лайф даатгал	77.5	75.9	-6.6	99.7	314.6	215.5%
2	Мандал лайф даатгал					50.0	-
Нийт		77.5	75.9	-6.6	99.7	364.6	265.7%

Давхар даатгалын компани							
1	Үндэсний давхар даатгал	2,833.3	2,410.22	1,870.0	2,186.8	2,397.3	9.6%
2	Хубилай давхар даатгал	1,557.4					
Нийт		4,390.7	2,410.2	1,870.0	2,186.8	2,397.3	9.6%
Даатгагчдын нийт дүн		12,571.6	11,738.9	11,034.4	9,213.1	7,388.1	-19.8%


2.9. ДАВХАР ДААТГАЛ



Давхар даатгалын хураамж **100.4** тэрбум төгрөг байна.

Тайлант хугацаанд ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийт 97.9 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамж төлсний 6.5 хувь буюу 6.5 тэрбум төгрөгийг дотоодын давхар даатгагчид төлсөн байна. Давхар даатгалын нөхөн төлбөр, хураамжийн харьцааг 2022 оны 3 дугаар улиралтай харьцуулахад 45.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. /Дүрслэл №14 болон Хүснэгт №10-т тус тус дэлгэрэнгүй харуулав/

Дүрслэл №13. Давхар даатгалын хураамж, нөхөн төлбөрийн харьцаа



Хүснэгт №10. Давхар даатгалын хураамж

Давхар даатгалын хураамжийн зардал /сая.төг/						
№	Даатгалын компани	2019.III	2020.III	2021.III	2022.III	2023.III
Ердийн даатгал						
1	Монре даатгал	218.7	55.3	72.4	45.8	223.9
2	Ард даатгал	1,044.5	1,879.1	1,653.9	3,209.0	3,508.8
3	Бодь даатгал	14,315.1	17,676.6	32,784.3	5,468.6	3,965.0
4	Мөнх даатгал	0.0	227.9	902.4	135.7	1,176.4
5	Миг даатгал	6,924.1	1,092.1	2,329.4	4,756.2	7,004.2
6	Монгол даатгал	8,954.9	4,463.1	11,301.2	3,395.1	9,343.2
7	Тэнгэр даатгал	5,024.5	6,585.5	3,827.3	2,016.3	2,495.0
8	Номин даатгал	242.8	289.9	641.4	553.2	800.9
9	Улаанбаатар хотын даатгал	-	-	-	-	-
10	Амар даатгал	2,673.6	2,697.4	1,295.8	1,967.7	6,848.3
11	Ган зам даатгал	-	-	-	-	-
12	Практикал даатгал	1,332.6	7,151.9	4,280.7	1.0	6,750.1
13	Мандал даатгал	9,757.2	14,124.1	14,279.6	41,256.2	53,130.9
14	Хаан даатгал	394.1	460.6	1,566.3	1,992.1	2,374.0
15	Агула даатгал				1,665.8	251.5
16	Соёмбо даатгал	554.4	0.0			
Нийт		51,436.5	56,703.4	74,934.6	68,254.7	97,872.4
Урт хугацааны даатгал						
1	Нэйшнл лайф даатгал	19.4	17.9	19.2	20.7	24.2
2	Мандал лайф даатгал					0.1
Нийт		19.4	17.9	19.2	20.7	24.3
Давхар даатгал						
1	Үндэсний давхар даатгал	938.7	1,768.8	1,767.4	1,598.3	2,518.0
2	Хубилай давхар даатгал	0.0				
Нийт		52,394.5	58,490.1	76,721.2	69,873.7	100,414.7

3. ЕРДИЙН ДААТГАЛ

3.1. ЕРДИЙН ДААТГАГЧДЫН ХӨРӨНГӨ



Ердийн даатгагчдын хөрөнгө **495.6** тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос **30.7%**-аар өссөн байна.


Тайлант үед ердийн даатгагчдын нийт хөрөнгө 495.6 тэрбум төгрөг байгаагаас хамгийн их хувийг буюу 26.2 хувийг “Мандал даатгал” ХК, 10.1 хувийг “Миг даатгал” ХХК, 8.7 хувийг “Ард даатгал” ХК-ийн нийт хөрөнгө тус тус эзэлж байна. /Хүснэгт №11-д дэлгэрэнгүй харуулав /

Хүснэгт №11. Ердийн даатгагчдын хөрөнгө /ангилал тус бүрээр/

№	Даатгалын компани	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн /сая.төг/	Даатгалын авлагын дүн /сая.төг/	Хөрөнгө оруулалтын дүн /сая.төг/	Нийт хөрөнгийн дүн /сая.төг/	Эзлэх хувь
1	Монре даатгал	1,049.9	2,287.0	5,422.7	15,456.5	3.1%
2	Ард даатгал	2,643.5	4,251.6	23,539.9	43,134.4	8.7%
3	Бодь даатгал	1,168.9	2,980.5	15,830.6	29,926.9	6.0%
4	Мөнх даатгал	1,089.9	1,638.9	7,197.1	16,681.6	3.4%
5	Миг даатгал	4,146.2	5,803.6	29,416.7	49,940.4	10.1%
6	Монгол даатгал	3,598.3	1,291.5	7,247.0	34,805.0	7.0%
7	Тэнгэр даатгал	463.2	790.7	27,886.4	34,499.4	7.0%
8	Номин даатгал	778.6	12.5	18,649.2	22,199.8	4.5%
9	Улаанбаатар хотын даатгал	2,889.0	896.9	821.1	7,780.2	1.6%
10	Амар даатгал	2,587.2	3,078.7	12,519.4	22,531.3	4.5%
11	Ган зам даатгал	409.7	870.1	6,311.9	7,643.7	1.5%
12	Практикал даатгал	2,980.0	3,803.1	19,581.9	40,693.5	8.2%
13	Мандал даатгал	40,932.9	5,180.0	45,386.8	129,974.0	26.2%
14	Хаан даатгал	5,257.5	2,260.6	15,540.6	29,823.7	6.0%
15	Агула даатгал	356.5	454.0	3,707.4	10,549.3	2.1%
	Нийт	70,351.3	35,599.8	239,058.9	495,639.6	100.0%

Ердийн даатгагчдын хөрөнгийн 48.2 хувь буюу 239.0 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалт хэлбэрээр байршиж байгаа бөгөөд үүнээс 36.4 хувь буюу 86.9 тэрбум төгрөгийг үнэт цаасанд хөрөнгө оруулсан байна. /Дүрслэл №14-т дэлгэрэнгүй харуулав/

Дүрслэл №14. Ердийн даатгагчдын хөрөнгийн ангилал /эзлэх хувиар/



3.2. ЕРДИЙН ДААТГАГЧДЫН ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ

Тайлант үед ердийн даатгагчдын нийт өр төлбөрийн дүн 313.7 тэрбум төгрөг, нөөц сангийн дүн 230.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Хамгийн өндөр дүн бүхий 4 даатгалын компани (“Мандал даатгал” ХК, “Миг даатгал” ХХК, “Ард даатгал” ХК, “Практикал даатгал” ХХК)-ийн нөөц сангийн дүн ердийн даатгалын нийт нөөц сангийн дүнгийн 53.2 хувийг эзэлж байна. /Хүснэгт №12-т дэлгэрэнгүй харуулав/

Хүснэгт №12. Ердийн даатгагчдын өр төлбөр ба эздийн өмчийн дүн

№	Даатгалын компани	Нөөц сангийн дүн	Нийт өр төлбөрийн дүн	Эздийн өмчийн дүн	Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	Эзлэх хувь
